



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/092/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаангом хот 2026 он	Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Т.Батсүх Утас: 70453799, Цахим хаяг: Batsukht@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

### **1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

### **2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

- 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд
- 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
  - 3.5.1 Төсвийн төлөвлөлт
  - 3.5.2 Төсвийн гүйцэтгэл
  - 3.5.3 Нэмэлт төсөв
  - 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн
  - 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
  - 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
  - 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
  - 4.5.1 Завсрын аудитын талаар
  - 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

### **6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

#### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

УВС АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ  
АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА  
Ц.ЦЭВЭЭНРАВДАН ТАНАА

2026.02.25 № УВА-2026/092/ЧА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Увс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050541

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан/**

Дансны код	Балансын үзүүлэлт	төгрөг/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>84,585,172.86</b>	<b>63,655,172.86</b>
33300	Татаас, санхүүжилтийн авлага	20,930,000.00	0.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>63,655,172.86</b>	<b>63,655,172.86</b>
33510	Байгууллагаас авах авлага	26,966,871.86	26,966,871.86
33520	Хувь хүмүүсээс авах авлага	36,688,301.00	36,688,301.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>83,359,757.03</b>	<b>158,354,757.03</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>38,190,427.03</b>	<b>45,150,427.03</b>
35110	Тусгай зориулалттай материал	38,190,427.03	45,150,427.03
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>25,169,330.00</b>	<b>26,704,330.00</b>
35410	Бичиг хэргийн материал	1,534,980.00	1,294,980.00
35420	Аж ахуйн материал	17,814,350.00	19,589,350.00
35430	Сэлбэг хэрэгсэл	5,820,000.00	5,820,000.00
35600	Мал амьтад	20,000,000.00	20,000,000.00
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>167,944,929.89</b>	<b>222,009,929.89</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>612,654,720.03</b>	<b>790,813,954.89</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>503,644,720.03</b>	<b>682,643,954.89</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	487,208,445.84	578,708,445.84
39202	Хуримтлагдсан элэгдэл	-88,940,177.26	-107,142,403.24
39203	Авто-тээврийн хэрэгсэл	203,343,772.52	279,343,772.52
39204	Хуримтлагдсан элэгдэл	-160,526,883.60	-181,410,883.56
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	138,874,968.69	170,679,310.51
39206	Хуримтлагдсан элэгдэл	-97,220,157.83	-109,555,628.86
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,848,231.85	82,390,765.54
39208	Хуримтлагдсан элэгдэл	-22,943,480.18	-30,369,423.86
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,910,999.20	17,910,999.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	-17,910,999.20	-17,910,999.20
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>109,010,000.00</b>	<b>108,170,000.00</b>
39301	Програм хангамж	5,920,000.00	5,920,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,030,000.00	-4,870,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	107,120,000.00	107,120,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>612,654,720.03</b>	<b>790,813,954.89</b>

<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>780,599,649.92</b>	<b>1,012,823,884.78</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>21,501,911.81</b>	<b>26,529,030.33</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>21,501,911.81</b>	<b>26,529,030.33</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	5,909,147.33
41312	НДШ-ийн өглөг	0.00	3,166,693.39
41313	ХХОАТ-ын өглөг	0.00	2,742,453.94
<b>41320</b>	<b>Бараа үйлчилгээний зардлын өглөг</b>	<b>571,911.81</b>	<b>9,068,873.00</b>
413201	Бичиг хэргийн өглөг	0.00	1,844,200.00
413203	Түлш халаалтын өглөг	571,911.81	0.00
413205	Тээвэр, шатахууны өглөг	0.00	3,446,673.00
413206	Шуудан холбооны өглөг	0.00	220,000.00
413207	Албан томилолтын өглөг	0.00	3,558,000.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>20,930,000.00</b>	<b>11,551,010.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	10,651,010.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	20,930,000.00	900,000.00
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>21,501,911.81</b>	<b>26,529,030.33</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>759,097,738.11</b>	<b>986,294,854.45</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	790,071,309.76	790,071,309.76
51101	Өмч: - төрийн	790,071,309.76	790,071,309.76
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-294,477,865.96</b>	<b>-67,280,749.62</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-350,304,098.94	-294,477,865.96
51220	Тайлант үеийн үр дүн	55,826,232.98	227,197,116.34
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	263,504,294.31	263,504,294.31
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>759,097,738.11</b>	<b>986,294,854.45</b>
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>780,599,649.92</b>	<b>1,012,823,884.78</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>13</b>	<b>Татаас, санхүүжилтийн орлого</b>	<b>1,047,223,220.00</b>	<b>943,197,908.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>998,971,700.00</b>	<b>906,255,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	998,971,700.00	906,255,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>48,251,520.00</b>	<b>36,942,908.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,103,500.00	35,830,000.00

/төгрөг/

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,148,020.00	1,112,908.00
<b>12</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО</b>	<b>256,703,835.12</b>	<b>315,138,175.51</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>256,703,835.12</b>	<b>315,138,175.51</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,100,000.00	0.00
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,100,000.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	68,150,615.12	235,057,175.51
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	187,453,220.00	80,081,000.00
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,303,927,055.12</b>	<b>1,258,336,083.51</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,098,138,246.14</b>	<b>1,025,867,967.17</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>992,130,022.96</b>	<b>1,004,091,160.60</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>666,478,898.00</b>	<b>719,959,377.25</b>
210101	Үндсэн цалин	360,049,318.00	405,050,525.18
210102	Нэмэгдэл	202,762,211.00	203,614,988.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,705,000.00	61,064,364.00
210104	Урамшуулал	58,962,369.00	50,229,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>82,046,444.25</b>	<b>87,524,181.83</b>
210201	Тэтгэврийн даатгал	57,183,228.84	59,716,217.18
210202	Тэтгэмжийн даатгал	6,428,388.84	7,151,326.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,191,094.63	3,833,180.92
210204	Ажилгүйдлийн даатгал	2,954,256.82	3,385,834.89
210205	Эрүүл мэндийн даатгал	12,289,475.12	13,437,622.42
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>41,362,711.81</b>	<b>59,695,577.87</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,039,083.81	3,098,388.68
210302	Түлш, халаалт	36,462,624.00	53,278,720.19
210303	Цэвэр, бохир ус	1,861,004.00	3,318,469.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>33,401,798.71</b>	<b>27,835,109.00</b>
210401	Бичиг хэрэг	2,823,500.00	2,961,550.00
210402	Тээвэр, шатахуун	23,962,744.00	17,629,870.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,993,654.71	1,886,439.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,621,900.00	5,357,250.00

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>0.00</b>	<b>860,000.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	860,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,571,000.00</b>	<b>21,586,200.00</b>
210604	Урсгал засвар	6,571,000.00	21,586,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>16,191,000.00</b>	<b>6,889,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	16,191,000.00	6,889,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>80,273,928.00</b>	<b>14,053,274.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	70,427,140.00	2,422,960.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	632,000.00	632,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	801,000.00	2,546,850.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	363,208.00	191,884.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,640,000.00	7,860,000.00
210807	Газрын төлбөр	355,580.00	355,580.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>65,804,242.19</b>	<b>65,687,640.65</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,315,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,010,000.00	6,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,479,242.19	59,687,640.65
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>106,008,223.18</b>	<b>21,776,806.57</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>67,629,650.00</b>	<b>12,406,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,688,200.00	8,786,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	59,331,850.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,609,600.00	3,620,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>38,378,573.18</b>	<b>9,370,806.57</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,800,681.01	4,073,871.74
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	16,577,892.17	5,296,934.83
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,098,138,246.14</b>	<b>1,025,867,967.17</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>205,788,808.98</u></b>	<b><u>232,468,116.34</u></b>
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	149,962,576.00	5,271,000.00
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>149,962,576.00</b>	<b>5,271,000.00</b>

4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-149,962,576.00	-5,271,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>55,826,232.98</u>	<u>227,197,116.34</u>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	1,058,433,642.14	943,197,908.00
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	998,971,700.00	906,255,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	998,971,700.00	906,255,000.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>59,461,942.14</b>	<b>36,942,908.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,103,500.00	35,830,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,148,020.00	1,112,908.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,210,422.14	0.00
12	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО</b>	<b>1,100,000.00</b>	<b>20,930,000.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,100,000.00</b>	<b>20,930,000.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,100,000.00</b>	<b>20,930,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,100,000.00	0.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	0.00	20,930,000.00
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,059,533,642.14</u></b>	<b><u>964,127,908.00</u></b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,044,533,642.14</b>	<b>961,338,208.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>917,368,218.96</b>	<b>941,821,401.43</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>666,478,898.00</b>	<b>712,027,733.75</b>
210101	Үндсэн цалин	360,049,318.00	392,237,147.18
210102	Нэмэгдэл	202,762,211.00	214,668,486.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,705,000.00	56,648,776.00
210104	Урамшуулал	58,962,369.00	48,473,324.50
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>82,046,444.25</b>	<b>89,546,678.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	57,183,228.84	61,808,264.76
210202	Тэтгэмжийн даатгал	6,428,388.84	6,908,988.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,191,094.63	3,749,039.42
210204	Ажилгүйдлийн даатгал	2,954,256.82	3,415,997.21
210205	Эрүүл мэндийн даатгал	12,289,475.12	13,664,388.19
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>40,790,800.00</b>	<b>60,296,727.68</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,039,083.81	3,127,626.68
210302	Түлш, халаалт	35,890,712.19	53,850,632.00
210303	Цэвэр, бохир ус	1,861,004.00	3,318,469.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>27,834,148.71</b>	<b>19,380,948.00</b>

210401	Бичиг хэрэг	3,137,000.00	877,350.00
210402	Тээвэр, шатахуун	17,557,744.00	14,166,197.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,993,654.71	1,637,201.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,145,750.00	2,700,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,623,000.00</b>	<b>22,930,200.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	865,000.00	0.00
210604	Урсгал засвар	9,758,000.00	22,930,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>16,191,000.00</b>	<b>3,331,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	16,191,000.00	3,331,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>59,293,928.00</b>	<b>28,307,314.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	49,447,140.00	20,930,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	632,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	801,000.00	365,850.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	363,208.00	191,884.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,640,000.00	6,420,000.00
210807	Газрын төлбөр	355,580.00	355,580.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>14,110,000.00</b>	<b>6,000,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,100,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,010,000.00	6,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>127,165,423.18</b>	<b>19,516,806.57</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>67,856,850.00</b>	<b>10,146,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,695,400.00	8,786,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	59,331,850.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,829,600.00	1,360,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>59,308,573.18</b>	<b>9,370,806.57</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,800,681.01	4,073,871.74
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	37,507,892.17	5,296,934.83
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)</b>	<b><u>1,044,533,642.14</u></b>	<b><u>961,338,208.00</u></b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>15,000,000.00</u></b>	<b><u>2,789,700.00</u></b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>15,000,000.00</b>	<b>2,789,700.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>15,000,000.00</b>	<b>2,789,700.00</b>
<b>2251</b>	<b>Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн</b>	<b>15,000,000.00</b>	<b>0.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,000,000.00	2,789,700.00
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>15,000,000.00</b>	<b>2,789,700.00</b>
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-15,000,000.00</u></b>	<b><u>-2,789,700.00</u></b>

14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<u>0.00</u>	<u>0.00</u>
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<u>0.00</u>	<u>0.00</u>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл	790,071,309.76	263,504,294.31	-350,304,098.94	703,271,505.13
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	790,071,309.76	263,504,294.31	-350,304,098.94	703,271,505.13
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	55,826,232.98	55,826,232.98
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	790,071,309.76	263,504,294.31	-294,477,865.96	759,097,738.11
D01	2025 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл	790,071,309.76	263,504,294.31	-294,477,865.96	759,097,738.11
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	790,071,309.76	263,504,294.31	-294,477,865.96	759,097,738.11
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	227,197,116.34	227,197,116.34
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	790,071,309.76	263,504,294.31	-67,280,749.62	986,294,854.45

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
12200	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,044,327,900.00	902,181,128.26	142,146,771.74
122005	Төсвөөс санхүүжих	1,044,327,900.00	902,181,128.26	142,146,771.74
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,044,327,900.00	902,181,128.26	142,146,771.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,044,327,900.00	902,181,128.26	142,146,771.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	941,222,900.00	892,035,128.26	49,187,771.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	690,938,600.00	690,189,025.13	749,574.87
210101	Үндсэн цалин	384,991,200.00	392,237,147.18	-7,245,947.18
210102	Нэмэгдэл	228,701,300.00	192,829,777.45	35,871,522.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,781,400.00	56,648,776.00	-25,867,376.00
210104	Урамшуулал	46,464,700.00	48,473,324.50	-2,008,624.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,228,600.00	86,852,321.45	376,278.55
210201	Тэтгэврийн даатгал	60,685,000.00	59,950,974.40	734,025.60
210202	Тэтгэмжийн даатгал	6,641,700.00	6,690,601.34	-48,901.34

210203	ҮОМШӨ-ний даатгал	3,331,000.00	3,639,845.71	-308,845.71
210204	Ажилгүйдлийн даатгал	3,314,100.00	3,314,100.00	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,256,800.00	13,256,800.00	0.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>63,242,800.00</b>	<b>60,296,727.68</b>	<b>2,946,072.32</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,181,500.00	3,127,626.68	3,053,873.32
210302	Түлш, халаалт	53,860,700.00	53,850,632.00	10,068.00
210303	Цэвэр, бохир ус	3,200,600.00	3,318,469.00	-117,869.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>28,277,200.00</b>	<b>18,268,040.00</b>	<b>10,009,160.00</b>
210401	Бичиг хэрэг	4,050,000.00	877,350.00	3,172,650.00
210402	Тээвэр, шатахуун	14,258,000.00	13,053,289.00	1,204,711.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,123,200.00	1,637,201.00	3,485,999.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	216,000.00	0.00	216,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,630,000.00	2,700,200.00	1,929,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>31,108,900.00</b>	<b>25,719,900.00</b>	<b>5,389,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,052,000.00	2,789,700.00	2,262,300.00
210604	Урсгал засвар	26,056,900.00	22,930,200.00	3,126,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>12,500,000.00</b>	<b>3,331,800.00</b>	<b>9,168,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	12,500,000.00	3,331,800.00	9,168,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>26,553,600.00</b>	<b>7,377,314.00</b>	<b>19,176,286.00</b>
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	12,377,800.00	0.00	12,377,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	685,000.00	0.00	685,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,280,000.00	365,850.00	2,914,150.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо	406,000.00	191,884.00	214,116.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	211,500.00	44,000.00	167,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,300,000.00	6,420,000.00	1,880,000.00

210807	Нийтлэг үйлчилгээний төлбөр, хураамж	1,293,300.00	355,580.00	937,720.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,373,200.00</b>	<b>0.00</b>	<b>1,373,200.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,003,200.00	0.00	1,003,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	370,000.00	0.00	370,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>103,105,000.00</b>	<b>10,146,000.00</b>	<b>92,959,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>103,105,000.00</b>	<b>10,146,000.00</b>	<b>92,959,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	21,805,000.00	8,786,000.00	13,019,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	64,831,300.00	0.00	64,831,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,068,700.00	0.00	14,068,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,400,000.00	1,360,000.00	1,040,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>1,044,327,900.00</b>	<b>902,181,128.26</b>	<b>142,146,771.74</b>

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	Зөрүү
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>52,575,973.17</b>	<b>-52,575,973.17</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>52,575,973.17</b>	<b>-52,575,973.17</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>52,575,973.17</b>	<b>-52,575,973.17</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>0.00</b>	<b>21,838,708.62</b>	<b>-21,838,708.62</b>
210102	Нэмэгдэл	-	21,838,708.62	-21,838,708.62
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>0.00</b>	<b>2,694,356.55</b>	<b>-2,694,356.55</b>
210201	Тэтгэврийн даатгал	-	1,857,290.36	-1,857,290.36
210202	Тэтгэмжийн даатгал	-	218,387.08	-218,387.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	109,193.71	-109,193.71
210204	Ажилгүйдлийн даатгал	-	101,897.21	-101,897.21
210205	Эрүүл мэндийн даатгал	-	407,588.19	-407,588.19

2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	0.00	1,112,908.00	<b>-1,112,908.00</b>
210402	Тээвэр, шатахуун	-	1,112,908.00	-1,112,908.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	0.00	<b>20,930,000.00</b>	<b>-20,930,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	20,930,000.00	-20,930,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	0.00	<b>6,000,000.00</b>	<b>-6,000,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	6,000,000.00	-6,000,000.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	<b>31,645,973.17</b>	<b>-31,645,973.17</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	<b>31,645,973.17</b>	<b>-31,645,973.17</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	30,533,065.17	-30,533,065.17
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,112,908.00	-1,112,908.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь Хүнс, хөдөө аж ахуй болон хөнгөн, жижиг дунд үйлдвэрийн салбарын чиглэлээр гарсан хууль, тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд хариуцан зохион байгуулж, хүн амын хүнсний хангамж, баталгаат байдлыг дээшлүүлэх, малын чанар, үүлдэр угсаа, ашиг шимийг сайжруулан эрчимжсэн аж ахуй, газар тариалан жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх замаар салбарын өсөлтийг нэмэгдүүлэхэд анхаарч ажилладаг байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль
- Малыг генетик нөөцийн тухай хууль Т
- ариалангийн тухай хууль
- Хүнсний тухай хууль
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль
- Органик хүнсний тухай хууль
- Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль
- Хоршооны тухай хууль
- Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль

- Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль
- Компанийн тухай хууль
- Жижиг дунд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг гааль болон НӨАТ-аас чөлөөлөх тухай хууль
- Инновацын тухай хууль
- Авлигын эсрэг хууль
- Хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, 07 дугаар сарын 09-ний өдөр,
- Татварын ерөнхий хуульд 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр,
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Увс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж болон, нягтлан бодох бүртгэлийн стандарт бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 232,224.3 мянган төгрөгөөр буюу 29.7 хувиар өссөн байна.

**Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт**

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	84,585.2	63,655.2	-20,930.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	83,359.8	158,354.8	74,995.0
Үндсэн хөрөнгө	612,654.7	790,814.0	178,159.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>780,599.6</b>	<b>1,012,823.9</b>	<b>232,224.3</b>
Өр төлбөр	21,501.9	26,529.0	5,027.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	759,097.7	986,294.8	227,197.20
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>780,599.6</b>	<b>1,012,823.9</b>	<b>232,224.3</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэлгүй байна.

Авлагын дансны эхний үлдэгдэл нь өмнөх оноос 20,930.0 мянган төгрөгөөр буюу 24.7%-иар буурсан байна. Энэхүү авлага нь 2022, 2023, 2024 онуудад газар тариалан эрхэлдэг иргэнд засгийн газраас хөнгөлөлттэй хүнсний ногооны үрийг аймгийн 19 суманд тарааж олгосон.

Бараа материалын дансны үлдэгдэл 158,354.7 мянган төгрөг болж 74,995.0 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй шилжиж ирсэн материалын орлогоос голлон шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн данс нь 790,814.0 мянган төгрөг болж 178,159.3 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө 235,057.1 мянга, төсвийн хөрөнгөөр 2,789.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, тайлант онд 59,687.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 26,529.0 мянган төгрөг болж 5,027.1 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагад төлөх өглөг нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 986,294.8 мянган төгрөг болж 227,197.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,802,017.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалыг 690,938.6 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийг 81,263.7 мянга, байр ашиглахтай холбоотой зардалд 63,242.8 мянга, хангамж бараа материалын зардлыг 28,227.2 мянга, томилолтын зардлыг 12,500.0 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 31,108.9 мянга, нэг удаагийн зардлыг 2,400.0 мянга бусдаар

гүйцэтгүүлэх бараа үйлчилгээний бусад зардлыг 26,553.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 1,373.2 мянган төгрөг нийт 1,044,327.9 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 757,689.8 мянган төгрөгөөр бууруулан тодотгол хийж төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,044,327,9 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 906,255.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 902,181.1 мянган төгрөг буюу 86.4 хувьтай байгаа нь Үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 32,736.3 мянга, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлыг 92,958.8 мянган төгрөг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70803-Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх	6,977.8	6,977.8	0	0%
	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал				
2	70805-Эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх	1,037,350.1	906,255.0	131,095.1	87.3%
	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	928,845.1	896,108.1	32,736.3	96.4%
	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	103,105.0	10,146.2	92,958.8	9.8%
	81569-Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилээр гүйцэтгүүлэх	5,400,000	5,400,000	0	0%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн**

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл	5,920.0	5,920.0	Dynamic, asolous, Малын удам зүйн программ, Сум хөгжүүлэх сангийн программ зэрэг 4 программ данс бүртгэлд бүртгэлтэй байна.
2	Унаа, хоолны зардал	30,781.4	56,648.8	Унаа хоолны зардлыг өдрийн 15.0 мянган төгрөгөөр тооцон олгож байна.
3	Сургалт, семинар	6,010.0	6,000.0	Сургалтын зардалд 6,000.0 мянган төгрөг зарцуулсан байна.
4	Гадаад томилолт, арга хэмжээ	0.0	0.0	Гадаад томилолтын зардал байхгүй байна.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	0.0	0.0	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Орон тооны цомхотгол	0.0	0.0	Орон тооны цомхотгол хийгдээгүй байна.
7	Хэвлэл, мэдээлэл	0.0	0.0	Хэвлэл, мэдээллийн зардал байхгүй байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд Засаг даргын тамгын газраас 35,830.0 мянган төгрөгийн орлого, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас 1,112.9 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх 20,900.0 мянган төгрөг, нийт 57,872.9 мянган төгрөгийн орлогыг зарцуулах эрх нээлгэн 52,575.9 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, 5,296.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.  
**3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### **3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайлант онд тендер худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, харин байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах 30,202.9 мянган төгрөгийн бараа материал, 2,789.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шууд худалдан авалт хийсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторовын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Батсүх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Увс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 45 дугаар албан бичгээр ирүүлсэн.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,119,068.2 мянган төгрөгийн 1 хувиар буюу 11,190.7 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 8,982.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,025,868.0 мянган төгрөгийн 1 хувиар буюу 10,258.7 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 8,206.9 мянган төгрөгөөр тогтоосон.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Увс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Увс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 159, хугацаа хоцроосон 12 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад бусад хууль тогтоомжтой холбоотой горим сорил хэрэгжүүлээгүй болно.

### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

#### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Увс аймгийн Увс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

#### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй бөгөөд зөвлөмж өгөөгүй байна.

### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар 20,853.8 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчил илэрснээс 19,000.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 1,853.8 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

1. Увс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь тайлант онд урсгал засварын зардлаас 19,000.0 мянган төгрөгийн байрны тохижилтыг "Оссо Соёо" ХХК-тай гэрээ байгуулан хийж гүйцэтгүүлсэн байна. Энэхүү зардлыг тайлант онд байгууллагаас авах авлага дансанд бүртгэсэн байсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад "Үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.6 дахь заалтад "Бүх зардал" Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул залруулга хийлгэлээ.

## 5.1 Зөвлөмж

Илрүүлэлт:

### 1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

#### 1.1. Илрүүлэлт:

Увс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 1,853.8 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад "Үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" 14.4.1 дэх заалтад "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.6-д "бүх зардал" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй нь Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### 1.2. Өгсөн зөвлөмж:

Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг үнэн зөв тайлагнах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайлант хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлага дансанд буруу бүртгэсэн.	1	19,000.0			1	19,000.0	1	19,000.0				
Дүн	1	19,000.0			1	19,000.0	1	19,000.0				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалинг НДШ-ийн тайланд тайлагнаагүй	1	1,853.8					1	1,853.8				
Дүн	1	1,853.8					1	1,853.8				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

*[Signature]* /Г.БАТСҮХ/

2026 оны 02 дугаар сарын 25-ны өдөр